



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны
хангалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Иргэний нисэхийн салбарын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, ажлын үр дүнг дээшлүүлэх, сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалтыг сайжруулах чиглэлээр Иргэний нисэхийн ерөнхий газарт:

1.1 Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын дүрэм, журмын хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг сайжруулах, иргэний нисэхийн дүрмийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа 2020 оны 9 дүгээр сард багтаан Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлэх;

1.2 Нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчдэд тавигддаг шаардлагын хэрэгжилтийг нарийвчлан шалгах, холбогдох сургалт, дадлагыг хэрхэн зохион байгуулж, иргэний нисэхийн дүрмийн шаардлагад нийцүүлж байгааг тогтоож, сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авах;

1.3 Хуваарьт нислэгт ашиглаж буй агаарын хөлгүүдийн хөдөлгүүрийн техникийн байдалд үзлэг шалгалтыг тусгайлан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сайжруулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулах;

1.4 Орон нутгийн нисэх буудлуудын аэродромын байдалд үзлэг, шалгалт хийх, агаарын хөлөг шувуутай мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч, дүнг 2020 оны 9 дүгээр сард багтаан танилцуулах;

Хоёр. Нислэг техникийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд:

2.1 Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдал, нислэг техникийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг нэгтгэн судалж, тайлагнах;

2.2 Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдал болон зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой албан тушаалтан, ажилтанд хариуцлага тооцох саналын хамт Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлд 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулах.

Гурав. Өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийг баримтлах, гамшиг, цаг агаарын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Иргэний нисэхийн ерөнхий газар,

08 047

"МИАТ" ТӨХК, "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК, агаарын тээврийн компаниуд болон холбогдох байгууллагын удирдах албан тушаалтанд:

3.1 Улсын онцгой комиссоос Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлж буй шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллах;

3.2 Цаг агаарын болзошгүй эрсдэл, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, шаардлагатай нөөцийн бэлэн байдал, ажлын зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж мэдээллээр хангах;

3.3 Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн нөөц бололцоог бүрэн ашиглаж, төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлуудыг график гарган, хугацаанд нь дуусгах;

3.4 Иргэний нисэхийн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажилд онцгойлон анхаарч, намар өвлийн навигацид шилжих урьдчилсан үзлэг шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр шуурхай арилгаж, бэлтгэл ажлыг бүрэн хангаж, эргэн тайлагнах;

3.5 Гамшиг, цаг агаарын болзошгүй аюул, эрсдэлийн талаар шуурхай мэдээлэл дамжуулах тогтолцоог тус тусын чиг үүргийн дагуу бүрдүүлэн хэрэгжүүлэх;

3.6 Орон нутгийн нисэх буудлуудын үер усны хамгаалалт, галын аюулгүй байдлын үзлэгийг хийж, эзэмшил газар, аюулгүйн бүсийг баталгаажуулах ажлыг нэн даруй хийх.

3.7 Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал /"Чингис хаан" олон улсын нисэх буудал/-ыг ашиглалтад сруулах нэгдсэн төлөвлөгөөнд тодотгол хийж, үйл ажиллагааг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, тус тусын чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх ажлыг график гарган ажиллах;

Дөрөв. Албан даалгаврын биелэлтийг тус тусын чиг үүргийн дагуу хангуулж, хэрэгжилтийн явцыг сар бүр тайлагнаж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/, "МИАТ" ТӨХК /Д.Баттөр/, "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК /Л.Цэнгүүнжав/-д даалгаж байна.

Тав. Албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/-т даалгаж байна.

Зургаа. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т хариуцуулж байна.

